



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 4/300

Мандалговь

Сургуулийн өмнөх боловсролын
сургалтын байгууллага байгуулж,
тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын газрын 2019 оны 130 дугаар тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан суманд 8 дугаар цэцэрлэгийг 2019 оны 8 сарын 27-ны өдрөөс байгуулж ажиллуулсугай.

Хоёр. Сайнцагаан сумын 8 дугаар цэцэрлэгт сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн тооцож 4 жилийн хугацаатайгаар олгохыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга (Ц.Бумангэрэл)-т зөвшөөрсүгэй.

Гурав. Боловсролын үйлчилгээтэй холбогдсон төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Сайнцагаан сумын 8 дугаар цэцэрлэгийн эрхлэгч (Л.Оюун)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Сайнцагаан сумын 8 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм, нормативыг сахин мөрдөж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн Бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газрын дарга (Ц.Бумангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190870